



О.ПҮРЭВСҮРЭН

Хууль сахиулахын их сургуулийн

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн


Нийгмийн аяслын тэнхимийн ахлах багш, ахмад

*Хүний хөгжил хэрэгчлээгээрээ биш,
бүтээх чадвараар хэмэсигддэг*

ХОРИХ ЯЛ ЭДЛЭГСДИЙГ НИЙГЭМШҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН АЖИЛТНЫ ОРОЛЦООГ ХАНГАХ НЬ

Монгол улсын хорих байгууллагад ял эдлэгсдийг хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх, гэгээрүүлэх ажил олон арван жилийн туршид янз бүрийн түвшинд явагдаж ирсэн төдийгүй тухайн хоригдогч гэм буруутай нь тогтоогдож шүүхээр ял шийтгүүлсэн хүмүүс хэдийгээр нас, хүйс, боловсрол, үйлдсэн гэмт хэргийн хүнд, хөнгөний хувьд ялгаатай ч тэднийг хүмүүжүүлэх, сургах, мэргэжил эзэмшүүлэх, хөдөлмөрийн дадлага олгох, нийгэм, сэтгэл зүйн мэргэжлийн үйл ажиллагааг хорих анги, шийдвэр гүйцэтгэх албанд нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нар ажил үүргийн хуваарийн дагуу гүйцэтгэж байна.

Хоригдогчдын тоон үзүүлэлт



Ө н ө д р и й н байдлаар хорих болон баривчлах ялаар шинээр шийтгэгдсэн хоригдогсдын дундах давтан гэмт хэрэг үйлдэгсдийн тоон үзүүлэлт нь 2009 онд 1568 буюу 30.9%, 2010 онд 1988 буюу 34.2%, 2011 онд 2142 буюу 36.8%. 2012 онд 1580 буюу 24.3%, 2013 онд 1430 буюу

22% байгаа нь жилээс жилд өсөн нэмэгдэж, давтан гэмт хэрэг үйлдсэн ялтны тоо төдийлэн буурахгүй байна. Энэ нь Монгол улсын Эрүүгийн

хуульд заасан Эрүүгийн хариуцлагын зорилго бүхий гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, хүмүүжүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зэрэг зорилго хангагдахгүй байна гэж үзэх үндэслэлтэй болж байгаа юм.

Эдгээр зорилгыг бодит болгох ялангуяа хорих ял эдлэж буй хүн бүрт хүмүүжлийн нөлөө эерэг үзүүлэх зорилго нь хорих байгууллагын нийгмийн ажилтан, сэтгэл зүй, ажилтан, албан хаагч тэр дундаа хорих байгууллагын харуул хамгаалалтын ажилтан нарын үүрэгт шууд хамааралтай. Учир нь хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны харуул хамгаалалтын ажилтан нь 24 цагийн үүрэг гүйцэтгэх төдийгүй хоригдогч, ялтны талаар тодорхой мэдээлэлтэй, дотны туслалцаа авах боломжтой анхдагч субъект болж явдаг учраас хорих ял эдлэгсдийг нийгэмшүүлэх үйл ажиллагаанд тодорхой үүрэгтэйгээр оролцдог юм.

Өнөөгийн байдлаар хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны харуул хамгаалалтын ажилтан нь дэглэм, харуул хамгаалалт эрхэлсэн дэд даргын удирдлага дор Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2008 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 51 тоот “Хорих ангийн харуул хамгаалалтын болон ялтанд хяналт тавих журам” тушаалыг үндэслэн ажиллаж байна. Мөн харуул хамгаалалтын ажилтан нь өөрийн үйл ажиллагаандаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйлчилгээний стандарт зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Ер хорих байгууллагын харуул хамгаалалтын албаны гол чиг үүрэг нь ялтныг олон нийтээс тусгаарлан, тэднээс үйлдэж болзошгүй гэмт үйлдэл, халдлагаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, түүнчлэн ялтны аюулгүй байдлыг хангахад оршино гэж заасан байна⁵⁹. Мөн Хорих ангийн харуул хамгаалалтын болон ялтанд хяналт тавих журам”-ын даалгавар гүйцэтгэгч хянагчийн үүргийг авч үзье

1. Ялтны байр, үйлдвэрлэлийн ажлын талбайд дэглэм, журам сахиулж, тэдний үйл ажиллагаанд хяналт тавих;
2. Оргох болон бусад гэмт хэрэг үйлдэж болзошгүй ялтныг байнгын хяналтанд байлгах;
3. Ялтныг тогтмол бүртгэх, чөлөөт цагаа хэрхэн өнгөрөөж байгаад хяналт тавих, ажил эхлэх, дуусах үед амьдралын болон үйлдвэрлэлийн бүсийн хооронд жагсааж, хуяглан хүргэх;
4. Удирдлага болон сөрөнхий жижүүрийн өгсөн нэмэлт үүргийг гүйцэтгэх;

59 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиас

5. Өөрийн хариуцсан объектод нэвтрэх, тээврийн хэрэгсэлд үзлэг, нэгжлэг хийх, гадны хүмүүсийг нэвтрүүлэхгүй байх гэж тусгаж өгсөн байгаа нь энэхүү даалгавар гүйцэтгэгч хянагчийн үүрэг зөвхөн хорих ял эдлэгсдийг хянах цагдах үүрэгтэй⁶⁰ болохыг зааж байна. Хорих байгууллагын харуул хамгаалалтын ажилтан нь үйл ажиллагаа нь харилцаагаар илрэх ёстой мөртлөө тухайн ажилтан хоригдогчтой харилцах, нийгэмшүүлэх үйл ажиллагаанд бие даан оролцох, хөгжих бололцоог хязгаарлаж өгсөн гэх үндэслэлтэй байна. Тухайн хүний үйл ажиллагаа, ажил нь харилцааны 80 хувьд тулгуурлан явагдаж байдаг гэдгийг эрдэмтэн судлаачид нотлон гаргасан байгаа нь харуул хамгаалалтын ажилтны ажиллах орчин нөхцөл хязгааралмагдмал байна гэж судлаачын зүгээс үзэж байна.

Тэгвэл түүхэн уламжлалаас авч үзвэл дараах гурван хамаарал бүхий заалт тусгагдаж ирсэн байна. Тухайлбал харуул хамгаалалтын ажил зөв сайн зохион байгуулагдаж, зарчимч хатуу дэг журам бүрэн тогтоогдон хэрэглэгдэж чадвал хоригдлын дотор явагдах улс төр, хүмүүжлийн ажил тэднийг хөдөлмөрөөр хүмүүжүүлэх аятай боломж бүрдүүлж өгдөг гэж тусгасан байна. Мөн харуул хамгаалалтын албаны үүрэгт: хоригдлуудыг харж сэргийлэн хамгаалах ба хорих газрын дотоод дэг журмыг хэвшүүлэн биелүүлэх зорилгоор, Засан хүмүүжүүлэх хуулийн дагуу хоригдлыг хорих газрын дүрэм, шаардлагыг ягштал биелүүлэх арга хэмжээнүүдийг байнга авч явуулан тэдэнд тэсвэр хатуужил олгох, хууль ёсыг сахиулдаг болгон, хүмүүжүүлэх явдал⁶¹ гэж үздэг байсан.

Дээрх түүхэн эх сурвалжаас үзэхэд хорих ял эдлэгсдийг хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх үйл ажиллагаанд харуул хамгаалалтын оролцоо маш чухал байр суурь эзэлж байсан гэж дүгнэлт хийх боломжтой юм.

Хоригдлуудын дунд явуулах нийгмийн ажлын бүхий л хэрэгсэл, арга, хэлбэр нь тэднийг нийгэмшүүлэх, нийгмийн нөхөн сэргээх, суллагдсаны дараа нийгэмд дасгахад чиглэгддэг. Эрх чөлөөгөө хасуулсан хүмүүст явуулах нийгмийн ажлын үүрэг нь бүх түвшний ажилтнуудын мэргэжлийн үйл ажиллагааны түлхүүр бөгөөд түүнд хоригдлын ар гэр, төрийн болон төрийн бус олон нийтийн байгууллага, мөн түүний засарч хүмүүжих, нийгэмших үйл явцад оролцдог бүх субъектүүд хамаардаг. Олон улсын стандарт, дүрмээр хорих байгууллагын нийгмийн ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх үйл явц нь тухайн мэргэжилтний бие даасан үйл ажиллагаа байхаар тодорхойлсон байна.

Харин дүрэм нь дэлхийн улс орнуудын хувьд заавал биелүүлэх үүргийг тулгадаггүй. Аливаа улс орон үндэсний онцлогоо хадгалан олон улсын стандартыг баримтлан хорихын практикт дэвшилттэйгээр хэрэглэх нь дээрх дүрмийн бодит шинж чанараар хэрэгжүүлэн ажиллаж ирсэн. Дэлхийн олон улсуудад нэг харуул хамгаалалтын ажилтанд оногдох тоон

60 Хууль зүй дотоод хэргийн сайдын "Хорих ангийн харуул хамгаалалтын болон ялтан д хяналт тавих журам"

61 "Хорих ангийн ахуй дэглэмийн байцаагчийн гарын авлага" 2001 он

үзүүлэлтийг авч үзэхэд ноогдох хоригдлын тоо харилцан адилгүй байна.

Улс, бүс нутаг	Албан хаагчдын тоо	Нэг ажилтанд оногдох	Хоригдлын тоо
Австрали	10368	1/02.3	
Шинэ Зеланд	3073	1/02.2	
Герман		1/02.3	
Швейцарь		1/02.3	
Япон	17378	1/04.	
Солонгос /?мн?д/	12354	1/04.5	
Хятад	280521	1/05.5	
Монгол		1/20.....	

Энэхүү тоон үзүүлэлтэн дээр анализ хийхэд олон улсын хорих байгууллагад хамгийн олон тоогоор ажиллаж байгаа ажилтан бол харуул хамгаалалтын ажилтан байна. Тиймээс ч хорих ял эдлэгсдийг нийгэмшүүлэх, хүмүүжүүлэх ажилд нийгмийн ажилтан, сэтгэл зүйчээс гадна харуул хамгаалалтын болон бусад ажилтан, албан хаагчдыг татан оролцуулан ажиллаж ирсэн байна.

Олон улсын хүний эрхийн баримт бичигт тусгаснаар авч үзвэл: Харуул хамгаалалтын ажилтан хяналтын гэх тодотголтой зарим тохиолдолд албадлага хэрэглэх эрх бүхий албан тушаалтнаас бусад ажилтнуудыг иргэний эрх зүйн орон тооны ажилтнууд байхаар томилдог ба цэргийн цолгүй энгийн байх нь илүү үр дүнтэй гэж үздэг байна.



Холбооны Бүгд Найрамдах Герман улсын Эрүүгийн ял эдлүүлэх хуулинд

Тус улсын харуул хамгаалалтын ажилтны 4 үндсэн үүргийн хүрээнд/зураг-1/ тодорхой ажлыг гүйцэтгэж ажилладаг байна. Үүнд:

Дүрэм журмын дагуу биеэ зөв авч явж байгаа эсэхийг нь хянах; Хоригдлын хувийн асуудалд тусалж, дэмжлэг үзүүлэх; Хоригдлын чөлөөт цагийн үйл ажиллагаанд хамтран оролцох;

Нийгмийн тусламжийн арга хэмжээнд хамтран оролцох, нөлөөлөх;

- Аюулгүй байдал, эмх цэгцийг хариуцах;
- Гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс олон нийтийг хамгаалах;
- Хоригдлыг эрх чөлөөтэй болоход нь бэлтгэх, туслах гэсэн үйл ажиллагааг гүйцэтгэж ажилладаг ⁶² байна.

62 О.Нүрэвсүрэн "Герман улсын хорих ял эдлүүлэх ажиллагаа" УБ., 2014 он

Харин хорих байгууллагын харуул хамгаалалтын ажилтанг 2 жилийн хугацаатай бэлтгэдэг ба сургалтын төлөвлөгөө нь нийт хичээлийн 70 хувийг дадлага ажил, 30 хувийг онолын хичээлээр үздэг байхаар сургалтын хөтөлбөрийг боловсруулсан байна.

Оросын Холбооны Улс

Оросын холбооны улсын хувьд хорих газраас суллагдах үед үзүүлэх үйлчилгээ нь илүү тодорхой хуульчилан зааж өгсөн байдаг ба хоригдогч суллагдах үед гэрт нь хүрэх замын зардал хоол хүнс хувцсаар бүрэн хангадаг байна. Мөн харуул хамгаалалтын ажилтан нь тахир дутуу болон жирэмсэн эмэгтэй болон насанд хүрээгүй ялтнуудыг ар гэрт нь хүргэж өгөх зэрэг⁶³ халамжын үйлчилгээг давхар гүйцэтгэдэг байна. Дээрх үйл ажиллагааны туршлагаас үзэхэд хорих байгууллагын харуул хамгаалалтын ажилтан хорих ял эдэлж байгаа ялтанд нийгэмшүүлэх үйлчилгээг практик үйл ажиллагааны түвшинд гүйцэтгэдэг байна.

Судалгааны дүгнэлт болох түүхэн уламжлал, Герман болон ОХУ улсуудын туршлагаас авч үзэхэд манай улсын хорих байгууллагын харуул хамгаалалтын ажилтныг нийгэмшүүлэх үйл ажиллагаанд татан оролцуулахад хэд хэдэн хүчин зүйл нөлөөлж байна гэж үзэж байна. Үүнд:

1. Хорих байгууллагын харуул хамгаалалтын ажилтны үүрэг, эрх зүйн орчинг шинэчлэн бүрдүүлэх.
2. Харуул хамгаалалтын ажилтныг бэлтгэж байгаа сургалтын хөтөлбөр, тогтолцоог улам боловсронгуй

болгох.

3. Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албан ажиллаж байгаа нийгмийн ажилтны ажлын ачаалал их байна. Хууль зүй, дотоод хэргийн сайд. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2008 оны 205/94 дугаар хамтарсан тушаалын нэг дүгээр хавсралтын № 1-т “ШШГЕГ-ын албан хаагчдын ажлын ачаалалын жишиг норматив”-ын Төвлөрсөн хорих ангид 200-250⁶⁴ хоригдолд нэг нийгмийн ажилтан ажиллахаар заасан байна, харин олон улсын жишиг нормативаас үзэхэд Герман улсад нэг нийгмийн ажилтанд 70-80 хоригдол байхаар зохицуулагдсан, Швейцарьт 600 хоригдолтой ангид 5-6 нийгмийн ажилтан буюу нэг ажилтанд 60-80 үйлчлүүлэгч ногддог, Оросын Холбооны Улсад нэг нийгмийн ажилтан дэглэмээс шалтгаалан хоригдогчын тоо 60-70 байхаар тогтоосон байна гэж заасан байна.

Мөн харуул хамгаалалтын ажилтан нь тус байгууллагын нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нарын дотны туслагч, чиглүүлэгч багш байх боломжтой юм.

Өнөөгийн хууль эрх зүйн шинэчлэлийн хүрээнд хорих анги, шийдвэр гүйцэтгэх албанд ажиллаж байгаа харуул хамгаалалтын ажилтанг хорих ял

63 С.А.Лузгин, М.И.Кузнецов. Хорих байгууллагын нийгмийн ажил УБ., 2009 он

64 Хууль зүй дотоод хэргийн сайдын, Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яамны сайдын хамтарсан “Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албанд ажиллах албан хаагчдын жишиг норматив батлах тухай” 2008 он

эдлэгсдийг нийгэмшүүлэх үйл ажиллагаанд татан оролцуулах нь зөвхөн нийгэмшүүлэх үйл ажиллагааг үр дүнтэй, хүртээмжтэй явуулаад зогсохгүй, Эрүүгийн ялын зорилго хангахад тодорхой үүрэг, ач холбогдолтой гэж үзэж байна.

ДҮГНЭЛТ

Аливаа улс орны хөгжлийн бодлогын үндсэн чиглэл нь нийгмийн гол үнэт зүйл болсон хүний хөгжлийг дэмжсэн нөхцөлд эерэг үр дүн гардаг гэдгийг угсаатны зүй, сэтгэл судлал, социологийн шинжлэх ухаан болон хүний хөгжлийн зүй тогтлыг судалдаг эрдэмтэн судлаачид нэгэнт тогтоосон байдаг.

Хүний хөгжил рүү чиглэсэн үйл ажиллагааны нэг хэсэг нь нийгмийнхээ эмзэг бүлэгт тусалж, тэдгээрийг нийгэмд тодорхой байр суурьтай, үүрэг хариуцлагатай болгон хөгжүүлэх буюу зарим тодорхой бүлгийн хүмүүсийг нийгэмшүүлэх асуудал бөгөөд энэ ажлын зөв, оновчтой арга хэлбэрийг тогтоох, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, бусад зорилтот бүлэгтэй хамтран ажиллах нь өнөөгийн шаардлагад нийцсэн чухал алхам болох юм.

Хоригдогсдын давуу тал буюу дотоод нөөц боломжийг илрүүлэх, бие даан амьдрах чадварт сургахад хорих байгууллагын нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийн үүрэг төдийгүй энэхүү хариуцлагатай үүргээ хэрэгжүүлэхийн тулд харуул хамгаалалтын ажилтны оролцоог хангах зорилго чиглэлийг хүрээнд олон талаас нь нарийвчлан судлаж тулгарч буй бэрхшээлтэй асуудлыг, илрүүлэн хоригдогчыг нийгэмшүүлэх ажлыг улам боловсронгуй болгох зорилгоор энэхүү ажлыг хийж гүйцэтгэсэн.

Цаашид хорих байгууллагад ял эдэлж байгаа ялтныг нийгэмшүүлэх ажлыг олон улсын жишиг хандлагад нийцсэн хэлбэр, тогтолцоо, зохион байгуулалттайгаар хийх зорилгоор дараах дүгнэлтэнд хүрлээ. Үүнд.

Түүхэн уламжлал, сурвалж бичигт хорих байгууллагын харуул хамгаалалтын ажилтан нь ялтныг хүмүүжүүлэх үүргийг өөрийн ажил үүрэг хуваарьт нь тусган өгч үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллаж ирсэн байна.

Герман болон бусад улсын хорих байгууллагын харуул хамгаалалтын ажилтныг бэлтгэдэг тогтолцоо, сургалтын хөтөлбөр, харуул хамгаалалтын ажилтны үүрэг зэргийг баримт, материалаас судалж үзэхэд харуул хамгаалалтын ажилтны үүрэгт тодорхойлон зааж нийгэмшүүлэх үйл ажиллагаанд татан оролцуулдаг байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2 дугаар сарын 22-ний өдрийн 51 тоот “Хорих ангийн харуул хамгаалалтын болон ялтанд хяналт тавих журам” тушаалд ял эдлэгсдийг нийгэмшүүлэх үйл ажиллагаанд татан оролцуулах үүрэг бүхий заалт, үг өгүүлбэр тусгагдаагүй байна.

Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албан ажиллаж байгаа нийгмийн ажилтны ажлын ачаалал их байгаа нь “ШШГЕГ-ын албан хаагчдын ажлын ачаалалын жишиг норматив”-аас харагдаж байна. Хорих ял эдлэгсдийг нийгэмшүүлэх үйл ажиллагаанд биечлэн оролцох боломжгүй байгаа нь харуул хамгаалалтын албаны чиг үүргээс тодорхой тусгагдсан байна.

САНАЛ

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2008 оны 2 дугаар сарын 22-ний өдрийн 51 тоот “Хорих ангийн харуул хамгаалалтын болон ялтанд хяналт тавих журам” тушаалын харуул хамгаалалтын үүрэгт ялтныг нийгэмшүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг тусалцаа үзүүлэх бүхий заалтыг тусгаж оруулах.

Хорих байгууллагын нийгмийн ажилтны ажлын ачаалал өндөр байгаа төдийгүй ажилтны ажлын үр дүнгийн үзүүлэлтэнд шууд нөлөөлж байна гэж үзэж байна. Иймд нийгмийн ажилтны жишиг нормативыг Олон улсын жишиг нийцүүлэн гаргаж мөрдлөг болгох.

Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны албан хаагч нарт хорих ял эдлэгсдийг нийгэмшүүлэх ажил зөвхөн нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийн үүрэг биш Эрүүгийн ялын зорилгыг хэрэгжилтийг хангахад нийт албан хаагчдын оролцоо чухал гэдгийг ойлгуулах, сэдэл төрүүлэх.

Харуул хамгаалалтын ажилтан, нийгмийн ажилтны хоорондын үйл ажиллагааг уялдуулах багаар хамтран ажиллах;

Хорих ангийн харуул хамгаалалтын ажилтан бэлтгэх сургалтын хөтөлбөрт нийгмийн ажил, сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх эмнэлэгийн анхан шатны тусламж үзүүлэх арга зүй гэх мэт хичээлийг зайлшгүй тусган оруулах, дадлага ажлыг хорих анги, шийдвэр гүйцэтгэх албадуудад 14-30 хоногийн хугацаатай хийлгэж холбогдох ажилтан буюу дадлага удирдагчын тодорхойлолтыг үндэслэн хорих байгууллагад томилон ажиллуулах;

Харуул хамгаалалтын ажилтан бэлтгэдэг сургалтыг 2 жилээс доошгүй хугацаагаар бэлтгэн дадлага ажлыг хорих анги дээр зохион байгуулж үнэлгээ дүгнэлт өгч байх;